

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭНИЙ МАЯГТ(З-ХХСБ)-ЫГ НӨХӨХ ЗААВАР

**Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ** эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Тусгай зөвшөөрлийн гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой тухайн жилийн тайлан, мэдээг дараа оны 02 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн тайлан, мэдээг тухайн оны 08 дугаар сарын 01-ний дотор маягтад тодорхойлсон үзүүлэлтийн дагуу <http://stat.crc.gov.mn> хаягаар цахим програмд шивж, Зохицуулах хороонд ирүүлнэ.

**Тайлант хугацаа** гэж жилийн эцсийн тайлан, мэдээний хувьд өмнөх оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг, хагас жилийн тайлан, мэдээний хувьд тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг ойлгоно.

### МАЯГТЫН НЭР ТОМЪЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

**НДШ** гэж нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт дүнг ойлгоно.

**ААНОАТ** гэж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

**НӨАТ** гэж нэмэгдсэн өртгийн албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

**ХХОАТ** гэж хувь хүний орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

**БНҮҮ сан** гэж тайлант хугацаанд бүх нийтийн үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг ойлгоно.

**Улс хоорондын сүлжээ** гэдэгт хил дамжин үзүүлж буй олон улсын ярианы, интернэтийн бөөний урсгал нийлүүлэх, транзит урсгал дамжуулах зэрэг улс хоорондын үйлчилгээ явуулахад зориулсан гадаад улсын сүлжээтэй холбогдсон суурь сүлжээг ойлгоно.

**Хот хоорондын сүлжээ** гэдэгт хот, аймаг, сумдыг холбосон өргөн зурвасын суурь болон түгээх сүлжээг ойлгоно. (Улаанбаатараас орон нутаг)

**Хот суурин газрын сүлжээ** гэдэгт хот, аймгийн төв, сум, суурин газрын дотор байгуулсан сүлжээг ойлгоно. Жич (Улаанбаатар хот дотор, Архангай аймаг)

**Суурь сүлжээ (core)** гэдэгт сүлжээний үндсэн зангилаа цэгүүдийг холбосон, өндөр багтаамж, хурд бүхий өргөн зурвасын сүлжээний хэсгийг ойлгоно. (Тухайлбал хот, аймгийн төвүүдийг холбосон сүлжээ)

**Түгээх сүлжээ (distributer)** гэдэгт суурь сүлжээнээс салбарлуулан хэрэглэгчийн сүлжээ хүртэл байгуулсан сүлжээг ойлгоно. (Тухайлбал аймгийн төвөөс сум, суурин газар луу байгуулсан сүлжээ)

**Хэрэглэгчийн сүлжээ (access)** гэдэгт түгээх сүлжээнээс салбарлуулан байгуулсан эцсийн хэрэглэгч хүртэлх сүлжээ (бүх төрлийн бүтэцтэй)-г ойлгоно.

**Зангилаа цэг** гэдэгт сүлжээний тогтвортой найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, зай тэжээлийн систем, барилга байгууламж бүхий холболтын болон дахин хуваарилалтын цэгийг ойлгоно.

**Интернэтийн зурвас (Bandwidth)** гэдэг нь тухайн интернэтийн сүлжээгээр дамжин өнгөрөх өгөгдлийн хамгийн дээд хэмжээ буюу хурдыг ойлгоно.

**IPLC (International Private Leased Circuit)** гэдэг нь хоёр болон түүнээс дээш улс орны хооронд байнгын, зориулалтын суваг бүхий хувийн холболтыг ойлгоно.

**Кейш сервер** гэдэг нь сүлжээгээр дамжиж буй өгөгдлийг түр хадгалах зорилготой сервер бөгөөд хэрэглэгчид ижил контентэд дахин хандахад илүү хурдан, үр ашигтай, сүлжээний ачаалал багатай байдлаар хүргэх үүрэгтэй.

### I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оршин байгаа байшин, байр, баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нэрийг бичиж, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодоос тохирох кодыг тус тус нөхнө.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын утасны дугаар, цахим шуудангийн хаяг болон тайлан, мэдээг хариуцан бөглөх ажилтны овог нэр, албан тушаал, утасны дугаар, цахим хаягийг тус тус нөхнө.

## II. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

**БАГАНА Г:** ХХЗХ-ны даргын 2022 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс мэдээ, тайлан бүрдүүлэх, түгээхэд баримтлах журмын 9.2-т заасны дагуу “Н1- Нууц гэж үзэх ба ийм тэмдэглэл бүхий үзүүлэлтийг Зохицуулах хороо зөвхөн өөрийн үйл ажиллагаанд ашиглана.”, “Н2- Нээлттэй мэдээлэл гэж үзэх ба аж ахуйн нэгжийг дурдаж, нийтэд мэдээлж болно.”

**БАГАНА 1:** Тухайн үзүүлэлтийн утгыг нөхнө. Ингэхдээ хэмжих нэгж тус бүрийг нягтлах.

**БАГАНА 2:** Тухайн үзүүлэлт тус бүрд нэмэлт тайлбар, тодруулга бичиж тэмдэглэх шаардлагатай тохиолдолд тэмдэглэлийг тусгана.

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

**Санхүүгийн үзүүлэлт хэсэг** нь Дүрмийн сангийн хэмжээ, Нийт орлого, Нийт зардал, Нийт хөрөнгө оруулалт, Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого хэсгүүдээс бүрдэнэ.

**МӨРИЙН ДУГААР:1 Дүрмийн сангийн хэмжээ мөрөнд** тайлант хугацааны байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ буюу санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг бичнэ. *Дүрмийн сангийн хэмжээ буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2-оос 6 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

**МӨРИЙН ДУГААР:2 Төрийн-** Төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой эсхүл төрийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь төрийн өмчийн тохирох дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:3 Орон нутгийн-** Орон нутгийн өмчийн, Орон нутгийн өмчийн оролцоотой эсхүл орон нутгийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь өмчийн тохирох дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:4 Хувийн, Монгол Улсын-** Дүрмийн сан дахь Монгол Улсын хувийн өмчийн дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:5 Хувийн, гадаадтай хамтарсан-** Гадаадын аж ахуйн нэгжтэй хамтарсан аж ахуйн нэгж бол дүрмийн сан дахь гадаад талын өмчийн дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:6 Гадаад улсын-** Гадаад улсын хөрөнгө оруулалттай бол гадаад улсын өмчийн дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:7 Нийт орлогын хэмжээ мөрөнд** тайлант хугацаанд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд олсон нийт орлогын дүнг бичнэ. *Нийт орлого буюу 7 дугаар мөрийн дүн нь 8-аас 18 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

**МӨРИЙН ДУГААР:8 Суваг түрээс, хот суурин газар - хот, аймгийн төв, сум, суурин газрын дотор үзүүлж буй суваг түрээсийн үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.**

**МӨРИЙН ДУГААР:9 Суваг түрээс, хот хооронд - хот, аймаг, сумдыг холбосон сүлжээг ашиглан үзүүлж буй суваг түрээсийн үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.**

**МӨРИЙН ДУГААР:10 Суваг түрээс, улс хооронд-** улс хоорондын сүлжээг ашиглан үзүүлж буй суваг түрээсийн (IPLC зэрэг) үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:11 Худаг, сувагчлалын түрээс-** өөрийн эзэмшлийн худаг, сувагчлалыг түрээслүүлж олсон олсон орлогыг дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:12 Байр талбайн түрээс-** Техникийн зориулалттай байр, талбай зэргийг түрээслүүлж олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:13 Цамхгийн түрээс-** Цамхаг түрээслүүлж олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:14 Шөрмөс түрээс-** шилэн кабелийн шөрмөс түрээслүүлж олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:15 Сүлжээ байгуулах, засвар үйлчилгээний орлого** – харилцаа холбооны дотоодын хэрэглээний сүлжээ байгуулах (байгууллагуудын салбар, цэгийг сүлжээгээр холбох зэрэг), сүлжээний гэмтэл саатал засварлах, ашиглалт үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:16 Улс хоорондын интернэтийн урсгал түрээс** – улс хоорондын интернэтийн урсгал түрээслүүлж олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:17 Улс хоорондын транзит үйлчилгээ** – Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх улс хоорондын транзит урсгал дамжуулах үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:18 Бусад** –Дээр дурьдагдаагүй бусад үйлчилгээний орлого байх ба тайлбар хэсэгт ямар орлого хамаарч байгааг бичнэ.

**МӨРИЙН ДУГААР:19 Нийт зардал мөрөнд** тайлант хугацаан дахь харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд гарсан нийт зардлын дүнг бичнэ. *Нийт зардал буюу 19 дүгээр мөрийн дүн нь 20-оос 32 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

Судалгаа, шинжилгээний ажлын зардал гэж байгууллагын бүх төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, урт ба богино хугацааны төлөвлөгөө боловсруулахад тусгайлан төсөвлөж зарцуулсан зардлыг ойлгоно.

**МӨРИЙН ДУГААР:33 Нийт хөрөнгө оруулалт мөрөнд** тайлант хугацаанд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын дүнг бичнэ. Хөрөнгө оруулалт хийсэн бол тайлбар хэсэгт хөрөнгө оруулалтын зориулалтыг дурдана. *Нийт хөрөнгө оруулалт буюу 33 дугаар мөрийн дүн нь 34-өөс 37 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

**МӨРИЙН ДУГААР:38 Төсөвт төвлөрүүлсэн орлого мөрөнд** тайлант хугацаанд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээг буюу ажиллах хүчний нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), ААНОАТ, НӨАТ, ХХОАТ, импортоор орж ирсэн бараа материал, тоног төхөөрөмжийн гаалийн татварын дүн, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (БНҮҮС)-д төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төрлийн татвар, хураамжийн нийлбэр дүнг бичнэ. *Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого буюу 38 дугаар мөр нь 39-ээс 45 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

## **ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

**Хүний нөөцийн үзүүлэлт хэсэг** нь нийт ажиллагчдын тоо, ажиллагчдыг нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, албан тушаалаар ангилсан тоо, дундаж цалингийн үзүүлэлтээс бүрдэнэ.

**МӨРИЙН ДУГААР:46 Нийт ажиллагчдын тоог бөглөхдөө** харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй нийт ажилтныг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.

*Нийт ажиллагчдын тоо буюу 46 дугаар мөр нь 47-оос 56 дугаар мөр дэх насны бүлгээр, 57-оос 58 дугаар мөр дэх хүйсээр, 59-ээс 67 дугаар мөр дэх боловсролын түвшинээр, 68-аас 77 дугаар мөр дэх ажил мэргэжлээр, 78-аас 84 дүгээр мөр дэх албан тушаалаар ангилсан ажиллагчдын тооны нийлбэртэй тус тус тэнцүү байна.*

*(ОУЦХБ-ын аргачлалын дагуу Full Time Employee – FTE буюу бүтэн цагийн ажилтай ажилтны тоо байна. Бүтэн бус цагийн ажилтай ажилтнуудыг 8 цагийн ажлын өдрөөр дүйцүүлж, бүтэн цагийн ажилтай ажилтанд шилжүүлж тооцно.*

*ҮСХ заавар: Нийт ажиллагчдын тоо гэдэгт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэдийг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.)*

Ажиллагчдын мэргэжлийн байдал нь албан тушаалтай хамааралгүй бөгөөд ажилтны эзэмшсэн мэргэжлийн код ангиллын дагуу тоог гаргана.

Албан тушаалын ангиллыг өөрийн байгууллагын бүтэц, ажлын байрны нэршилд дүйцүүлэн ойлгож, бөглөнө.

**МӨРИЙН ДУГААР:85-92 Дундаж цалин, албан тушаалаар-** Харгалзах албан тушаалын ажиллагчдын нийт цалинг харгалзах албан тушаалтнуудын тоонд харьцуулж гаргана

## **СҮЛЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

**МӨРИЙН ДУГААР:93 Сүлжээний нийт урт** гэдэгт өөрийн эзэмшлийн шилэн кабель, радио шугамын сүлжээний уртын нийлбэр байна. *Сүлжээний нийт урт буюу 93 дугаар мөрийн дүн нь 94-өөс 97 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

**МӨРИЙН ДУГААР:94-95 Шилэн кабелийн сүлжээний урт** гэдэгт өөрийн эзэмшлийн шилэн кабелийн сүлжээний уртыг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргасан, тус бүрийн нийлбэр урт байна.

**МӨРИЙН ДУГААР:96-97 Радио релейний шугамын урт** гэдэгт өөрийн эзэмшлийн радио релейний шугамын уртыг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргасан тус бүрийн нийлбэр урт байна.

**МӨРИЙН ДУГААР:98 Үүнээс тайлант хугацаанд нийт шинээр байгуулсан сүлжээний нийт урт** гэдэгт тайлант хугацаанд шинээр татсан өөрийн эзэмшлийн шилэн кабель, радио шугамын сүлжээний уртын нийлбэр байна. *Шинээр байгуулсан сүлжээний нийт урт буюу 98 дугаар мөрийн дүн нь 99-ээс 102 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

**МӨРИЙН ДУГААР:99-100 Шинээр байгуулсан шилэн кабель** мөрөнд тайлант хугацаанд шинээр татсан өөрийн эзэмшлийн нийт шилэн кабелийн сүлжээний уртын хэмжээг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргаж нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:101-102 Шинээр байгуулсан радио релей мөрөнд** тайлант хугацаанд шинээр байгуулсан өөрийн эзэмшлийн нийт радио релей сүлжээний уртын хэмжээг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргаж нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:103-104 Сүлжээний үйлчилгээ эрхлэгчид түрээслүүлж буй шөрмөс** гэдэгт өөрийн шилэн кабелийн шөрмөсийг бусад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанид түрээслүүлж буй уртын хэмжээг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргаж нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:105-106 Сүлжээний үйлчилгээ эрхлэгчээс түрээсэлж бус шөрмөс** гэдэгт бусад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниас түрээсэлж буй шилэн кабелийн шөрмөсийн уртын хэмжээ хэмжээг хот хооронд болон хот суурин газрын байршлаар ялган гаргаж нөхнө.

#### **УЛС ХООРОНДЫН СҮЛЖЭЭНИЙ БАГТААМЖ**

**МӨРИЙН ДУГААР:107 Гадаад урсгалын багтаамж** мөрөнд улс хоорондын холболтуудын нийт суурилагдсан дээд хэмжээ буюу зурвасын өргөний хүчин чадлын хэмжээ байна. *Гадаад урсгалын багтаамжийг гэрээ байгуулсан гадаад улсын оператор тус бүрээр гаргаж нийлбэрийг авна.*

**МӨРИЙН ДУГААР:108 Зурвасын ашиглалт** тайлант хугацаанд дамжуулсан нийт гадаад интернэт урсгалын хэмжээ байна. *Зурвасын ашиглалтын хэмжээг гэрээ байгуулсан гадаад улсын оператор тус бүрээр гаргаж, нийт дүнгийн хэмжээг авна.*

**МӨРИЙН ДУГААР:109 Түрээсэлсэн урсгал** мөрөнд интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани (ISP)-иудад гэрээгээр худалдсан багтаамж байна. *Түрээсэлсэн урсгалын хэмжээг гэрээ байгуулсан интернэтийн үйлчилгээ үзүүлэгч тус бүрээр гаргаж нийт дүнгийн хэмжээг авна.*

**МӨРИЙН ДУГААР:110 Улс хоорондын транзит урсгал** мөрөнд Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх улс хоорондын транзит урсгалын хэмжээ байна. *Улс хоорондын транзит урсгалын хэмжээг гэрээ байгуулсан гадаад улсын оператор тус бүрээр гаргаж нийт дүнгийн хэмжээг авна.*

**МӨРИЙН ДУГААР:111 Улс хоорондын хувийн түрээсийн (IPLC) сүлжээний урсгал** мөрөнд **Улс хоорондын хувийн түрээсийн (IPLC) сүлжээний** урсгалын нийт хэмжээ байна. *Улс хоорондын хувийн түрээсийн (IPLC) сүлжээний урсгалын хэмжээг гэрээ байгуулсан гадаад улсын оператор тус бүрээр гаргаж нийт дүнгийн хэмжээг авна.*

#### **ИДЭВХГҮЙ ДЭД БҮТЦИЙН МЭДЭЭЛЭЛ**

**МӨРИЙН ДУГААР:112 Худгийн нийт тоо** мөрөнд өөрийн эзэмшлийн нийт худгийн тоог нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:113 Сувагчлалын урт** мөрөнд өөрийн эзэмшлийн сувагчлалын нийт уртын хэмжээг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:114 Агаарын баганын нийт тоо** мөрөнд өөрийн эзэмшлийн агаарын баганын нийт тоог нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:115 Байр талбайн нийт тоо** мөрөнд өөрийн эзэмшлийн төхөөрөмж байршуулах зориулалттай нийт байр талбайн тоог нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:116 Байр талбайн хэмжээ** мөрөнд өөрийн эзэмшлийн төхөөрөмж байршуулах зориулалттай байр талбайн нийт хэмжээг нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:117 Цамхгийн нийт тоо** мөрөнд өөрийн эзэмшлийн нийт цамхгийн тоог нөхнө.

#### **ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

**МӨРИЙН ДУГААР:118 Сүлжээ, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлж буй харилцагч байгуулагуудын нийт тоо** мөрөнд холболтын гэрээ байгуулсан харилцагч байгууллагын тоог үйлчилгээний төрлөөр нь ялган гаргана. *Сүлжээ, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлж буй харилцагч байгуулагуудын нийт тоо буюу 118 дугаар мөрийн дүн нь 119-ээс 129 дүгээр мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

#### **ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**Сүлжээний бэлэн байдлыг (network availability)** тайлант хугацаанд гэмтэлгүй ажилласан нийт хугацааг, нийт ажиллах ёстой хугацаанд харьцуулж гаргана. Гэмтэл гэж тодорхой шалтгааны улмаас хэрэглэгч үйлчилгээ авах боломжгүй болсон нөхцөл байдлыг ойлгоно. Үүнд хэрэглэгчийн буруугаас шалтгаалсан хэрэглэгчийн төхөөрөмж, хэрэглэгчийн байршил доторх дотоод сүлжээний гэмтэл болон төлөвлөгөөт засвар үйлчилгээний түр саатлыг оруулж тооцохгүй.

**МӨРИЙН ДУГААР:130 Улс хоорондын сүлжээний бэлэн байдал мөрөнд** тайлант хугацаанд суурь сүлжээнд буюу бөөний үйлчилгээнд холбогдож буй сүлжээ, системийн бэлэн байдлыг тооцож нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:131 Хот хоорондын сүлжээний бэлэн байдал** мөрөнд тайлант хугацаанд хот, аймаг, сумдыг холбосон өргөн зурвасын суурь болон түгээх сүлжээний бэлэн байдлыг тооцож нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:132 Хот суурин сүлжээний бэлэн байдал** мөрөнд тайлант хугацаанд хот, аймгийн төв, сум, суурин газрын дотор байгуулсан сүлжээний бэлэн байдлыг тооцож нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:133 Гэмтэл засварласан дундаж хугацааг** мөрөнд тайлант хугацаанд гарсан нийт гэмтэл саатлыг засварласан хугацааг нийт гэмтэл саатлын тоонд харьцуулж тооцно.

**МӨРИЙН ДУГААР:134-136 Гэмтэл засварласан дундаж хугацаа, сүлжээний төрлөөр** мөрөнд тайлант хугацаанд суурь сүлжээ (core), түгээх сүлжээ (distribution), хэрэглэгчийн сүлжээ (access) тус бүрээр гарсан гэмтэл саатлыг засварласан хугацааг тэдгээрийн гэмтэл саатлын тоонд харьцуулж, тус бүрийн гэмтэл засварласан дундаж хугацааг тооцож нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:137 Журмын хугацаанд засагдаагүй гэмтлийн тоо** мөрөнд тайлант хугацаанд дотоод журмын хугацаанд засагдаагүй гэмтлийн тоог нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:138 Нийт гэмтлийн тоо** мөрөнд тайлант хугацаанд сүлжээнд гарсан нийт гэмтлийн тоог нөхнө.

**МӨРИЙН ДУГААР:139 Нийт гэмтлийн үргэлжилсэн хугацаа** мөрөнд тайлант хугацаанд гэмтлийн шалтгаан, төрлөөр нийт гэмтлийн хугацааг тооцно. *139 дүгээр мөрийн дүн нь 140-ээс 144 дүгээр мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
**Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар**  
**Судалгаа шинжилгээний хэлтэс**  
**Утас: 11-304258**

2025 он